

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГЫН ЭРСДЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2018 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2018.02.27

Улаанбаатар хот

д/д	Зөвлөмжид тусгагдсан үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хариуцах нэгж, албан тушаалтан
<b>Нэг. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг сайжруулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:</b>				
		1.1.1. Ажлын байрны шаардлагыг бүрэн ханган ажиллаж байгаа албан хаагчдыг тогтвортой ажиллах, дэвших боломжоор хангаж, төрийн албаны чадахуйц /мерит/ тогтолцоог төлөвшүүлэх, Авлигатай тэмцэх газрын дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилох;	-Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр арга хэмжээ авагдсан байх; -Хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалд томилогдох албан хаагч, иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хянуулсан байх;	Захиргааны удирдлагын газар
		1.1.2. Хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнаас хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан авах;	-Хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнаас хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүрэн авч, АТГ-т хүргүүлсэн байх;	Хяналт шалгалтын газар
		1.1.3. Албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар сургалт зохион байгуулах;	-Сургалтад нийт албан хаагчид хамрагдсан байх;	Хяналт шалгалтын газар
2	Ажлын байрны тодорхойлолтыг албан тушаалд томилогдох гэж буй этгээдэд тохируулан боловсруулж байгаа зөрчлийг таслан зогсоох, дахин ийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	1.2.1. Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг холбогдох журмын дагуу баталж, үр дүнгийн гэрээг байгуулах;	-Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт батлагдаж, үр дүнгийн гэрээ байгуулагдсан байх;	Захиргааны удирдлагын газар
<b>Хоёр. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах чиглэлээр:</b>				
		2.3.1. Иргэдээс цахим хэлбэрээр өргөдөл, гомдол, мэдээлэл, санал, хүсэлтийг хүлээн авах үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэдээллийн санд оруулж, шийдвэрлэлтийг удирдлагын	-Гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэх; -Мэдээллийн санд оруулсан байх; -Удирдлагын зүгээс байнга хянасан байх; -Иргэдийн зөрчигдсэн эрх хангагдсан байх;	Захиргааны удирдлагын газар

	шинэчлэн, цахимжуулах ажлыг эрчимжүүлэх, цахим гарын үсэг олгох, хаягжуулах, баталгаажуулах ажлыг түргэтгэх;	зүгээс байнга хянаж, хүний зөрчигдсөн эрх, эрх чөлөөг хангаж ажиллах;		
		2.3.2. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар цахим хуудсаар мэдээллэх;	-Иргэдэд мэдээлэл түргэн шуурхай хүрсэн байх;	Захиргааны удирдлагын газар
		2.3.3. Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах албан тушаалтны нэр, харилцах утас, иргэнийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулах;	-Мэдээллийг тухай бүр байршуулсан байх;	Захиргааны удирдлагын газар
		2.3.4. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч түүний хөрөнгийн талаарх мэдээлэл цуглуулах чиглэлээр Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газартай хамтран ажиллаж, үйл ажиллагааг онлайн хэлбэрээр зохион байгуулах;	-Хамтран ажиллах үйл ажиллагаа онлайн хэлбэрт шилжиж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа шуурхай явагдсан байх;	Шийдвэр гүйцэтгэх алба
		2.3.5. Шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөртэй эсэх талаарх лавлагаа, тодорхойлолтыг иргэнд Төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машинаар олгох, үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх;	-Төрийн үйлчилгээ цахим хэлбэрээр иргэдэд хүрсэн байх;	Шийдвэр гүйцэтгэх алба
Гурав. Худалдан авах ажиллагааны тогтолцоог сайжруулах чиглэлээр:				
4	Гэрээний үүргээ биелүүлээгүй, гэрээнд тусгагдсан хугацаа хоцроосон хуулийн этгээдэд хариуцлага тооцох;	3.4.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх чадвартай компанийг сонгох, гэрээнд тусгагдсан хугацааг баримтлахыг шаардах;	Гэрээгээр хүлээсэн үүрэг бүрэн биелэнэ, шаардлагатай бараа, ажил, үйлчилгээ цаг хугацаандаа нийлүүлэгдэнэ.	Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар
5	Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх, тэднийг сургах, чадавхижуулах, тендерийн үнэлгээний хороог байнгын бус ажиллагаатай байхаар	3.5.1. Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх сургалтад албан хаагчдыг хамруулах, тэднийг сургах, тендерийн үнэлгээний хороог байнгын бус ажиллуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ХЗДХЯам болон иргэний нийгмийн байгууллагын	Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн албан хаагчдын тоо нэмэгдэнэ, хөндлөнгийн хяналт сайжирна, хуулийн хэрэгжилт хангагдана.	Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар

	<p>зохион байгуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулах, тэдгээрийн хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх;</p>	<p>төлөөллийг оролцуулах, хяналт тавих нөхцөлийг сайжруулах;</p>		
6	<p>Тендерийн бичиг баримтын бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтан, үнэлгээний хорооны гишүүдийн ёс зүй, хариуцлагыг чангатгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;</p>	<p>3.6.1. Худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгалах, үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилтэй эсэх мэдэгдлийг тухай бүр авах;</p>	<p>Худалдан авах ажиллагааны бичиг баримтын хадгалалт, хамгаалалт сайжирна, үнэлгээний хорооны гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг тухай бүр хянана.</p>	<p>Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар</p>

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР